

МОНГОЛ-ТУВА БИЧГИЙН ХЭЛНИЙ ДУНДЫН ҮГИЙН
ГИЙГҮҮЛЭГЧ АВИАНЫ ТОХИРОЛ

Д. Баасанбаг*

Тува хэл судлалын хувьд одоо үед зайлшгүй судалж гүйцэтгэвэл зохих ард нийтэд танин ойлгуулах тулгамдсан асуудлын нэг бол монгол-тува хэлний харьцуулсан судалгаа юм. Түүхээс үзвэл Тувачууд нь өнө эртнээс төв азийн томоохон өндөрлөгүүд болох Тагна, Соён, Сийлхэм, Алтайн нурууны баруун зүүн биеэр нутаглаж байжээ. Хятадын сурвалж бичигт, МЭӨ I зууны үед “Дуба нар ихэвчлэн ой тайгаар амьдарч, ангийн хишгийг хүртэн амьдарч байсан бөгөөд, өвсөөр хучсан овоохой юмуу, холтсоор бүрсэн урцанд аж төрдөг, бугын арьсаар дээл хувцастай, ядуучууд нь шувууны өдөөр хувцас хийдэг байжээ. Сайн морьд уналга олонтой, цанаар гайхам хурдан гулгадаг, нэг удаагийн хүч авахад зуу орчим алхам газар маш хурдална. Тэд ял шийтгэл гэдгийг мэдэхгүй, хулгай хийж байгаад баригдвал нэг нугалж төлнө. Үхэгсдийг авсанд хийж ууланд тавих юмуу модонд өлгөнө. Өмнөх хөрш Хяргастай байнга байлдана, тухайн үедээ хөрш зэргэлдээ улс аймагтаа эзлэгдэж ангийн үнэт үсээр алба өргөж явсан байна”(4) гэж тэмдэглэжээ.

Зүүн Соён, Тагнын тайгад амьдарч байсан ойн иргэдийн тухай, “Эд нар ой тайгад амьдарч байснаар ийнхүү нэрлэгдэх болсон, гэр орон, майхан гэж мэддэггүй, амьтны арьсан дээлтэй, хонь ба үхрийн оронд уулын үхэр /цаа буга/ өсгөж сүүгий нь ууж, махыг нь иднэ. Хонь хариулахыг тэд нар маш уйтгартай, гутамшигт хэрэг гэж үзнэ. Тэр ч байтугай эцэг эх нь охиноо загнахдаа “Чамайг хонь хариулдаг хүний эхнэр болгож өгнө” гэхэд охин нь гоморхон гашуудахдаа өөрийгөө боомилон үхдэг ч байжээ. Уулын үхэрт нуруу ачин нүүж буусан газартаа модны холтсоор орон барьж, үүгээр хэрэгцээ нь хангагдана. Тэд нар энэ амьдралаас сайхан амьдрал хаана ч байхгүй гэж үздэг.” (14) гэж бичжээ.

Чингис хаан монголын нэгдсэн улсыг байгуулсны дараахан буюу 1207 онд Тува аймгийг эрхэндээ оруулж авсан тухай, “Туулай жил (1207 он) Зүчи баруун гарын цэргийг авч Ойрад, Буриад, Барга, Урсууд, Хабаханас, Хомханас, Тува аймгийг оруулаад ... ирэв.” (МНТ, 1990, 208) гэсэн нь ой тайгаар нутаглагч жижиг буурай аймгуудыг баруун гарын цэрэг онцын эсэргүүцэлгүйгээр эзэлж авсан түүхэн баримтыг дурджээ. 1757-1762 оны орчим Алтайн урианхайн долоон хошууг байгуулж Ховдын амбанд, Тагнын урианхайн дөрвөн хошууг байгуулж Улиастайн амбанд тус тус захируулсан бөгөөд, хожим Алтайн урианхай тувачууд монголдоо үлдэж,

* Монгол Улсын Их Сургууль, Монгол Хэл Соёлын Сургууль

Д. Баасанбат

Тагнын урианхай нар 1921-1944 оны хооронд бие даасан БНТУ болон оршин тогтнож байгаад ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсон билээ. Энэ бүх бодит баримтаас харвал 1207 оноос хойш тува монголчууд нэгэн төрийн дор нэгдэн түүхийн урт удаан хугацааг хамтдаа туулсан нь харагдаж байна. Энэхүү 800 гаруй жилийн хугацаанд монгол тува хэлний хооронд адилсах, хувьсах, шинэ нэр томъёо үүсэх, нийгмийн байгуулал өөрчлөгдөх тусам хэл ярианд гарсан өөрчлөлтүүд тува монголчуудад өөр өөрөөр нөлөөлж байсан зэрэг нь харагдаж байна. Тува монгол хэл нь гарал нэгтэй Алтай язгуурын хэл учраас түгээмэл зүй тогтол байхын сацуу өвөрмөц зүй тогтол байгааг бидний судалгаа батлан харуулж байна. “Хоёр хэлний түгээмэл зүй тогтол авиалбарын хувьд бүрэлдэхүүн, бүтэх арга, хувьслаар, үгийн бүтцийн хувьд язгуур+ дагавар+ нөхцөл гэсэн тогтолцоогоор өгүүлбэрийн бүтцийн хувьд SOV гэсэн гишүүний байрлалын хуулиар үгийн сангийн хувьд дундын үгийн бүрэлдэхүүнээр нотлогдоно.” (1)

Гийгүүлэгч авиаг сонсолзүйн талаас дуу, анирын оролцох байдал хийгээд хамжаас хашлагын онцлогийг харгалзаж сонсголт, шуугиант гэж ангилдаг.

Эрдэмтэн М.Базаррагчаа хэлний хэлбэр нь авиа, агуулга нь утга болно. Энэ хоёр нь бие биетэйгээ нарийн холбоотой болно. Хэлний агуулга нь бүтээвэр, үг, өгүүлбэр гэсэн үндсэн нэгжтэй бол хэлний хэлбэр нь түүнтэй тэнцэхүйц авиалбар, авианы үг, хэлц гэсэн үндсэн нэгжүүдтэй. Авиалбар нь бүтээврийн доод төвшний нэгж биш, харин бүтээвэртэй зэрэгцээ орших хэлний хэлбэрийн хамгийн бага нэгж ажээ. Иймээс авиалбар бүтээвэр хоёрын хэлхээ холбоо нь утгаа хэлний хэлбэр агуулга(утга) хоёрын нэгдэл, ялгараа болох бөгөөд энэ нь авиа сэлгэх ёсоор илрэх ажээ.(2)

Их эрдэмтэн И.А.Бодуэн де Куртенэ авиалбар сэлгэхийг “бүтээврийн хөдөлгөөнт бүрэлдэхүүн” гэж үзсэн байна.(5)

Эрдэмтэн В.И.Рассадин: Монгол хэлнээс тува хэлэнд нэвтэрсэн үгсийг тэмдэглэхдээ, тофалар хэл ч гэсэн хөөмийн эгшиг бий болсныг энэ үед бас хамруулан Гийгүүлэгчийн өмнө хөөмийн эгшиг тэмдэглэх нь бараг газар сайгүй үзэгдэх болжээ. Орчин цагийн монгол хэлний болон магадгүй өөр хэлний тулгуур бичиг дэх авиа, хоёр эгшигийн хоорондох гийгүүлэгчийг ганц нэгтэй жишиж болмоор байна.(3)

тув: *агар* “хонины хоёрдох хяргасан ноос намрын”, мон бич: *акар*, монг: *ахар*,
тув: *додар*, мук: *дотар*, *тотар*, мон бич: *дотур-а*, монг: *дотор*,
тув: *безерек* “цагаас өмнө бий болох, жижиг”, мон бич: *бэсэрэг*, монг: *бэсрэг*,
тув: *кажыыдаал* “шаналан, эмгэнэл”, мон бич: *гасигудал*, монг: *гашуудал*,
тув: *ижээн*, мон бич: *ичигэн*, монг: *ичээ* “могой болон бусад ичигсэд,
тув: *чечен (чечьччен)* “уран үгтэй мэргэн”, мон бич: *чэчэн*, *сэчэн*, монг: *цэцэн* тув: *чожу*
“зогтусах, цочих”, мон бич: *сочи-*, монг: *цочи* “айн цочих”,
тув: *кыда* “адууны тарган гургалдай”, мон бич: “*китай*”, монг: “*хятай*” гм.

Б.Х.Падаев: Монгол үсэг буюу “д-г”, мөн “г-х”-ээр хоорондоо сэлгэж болдгийг Тува буюу Урианхай хэл дээр хийсэн судалгаагаар монгол сэлгэлт гэдгийг нь ажиглан харж болно. Жишээ нь: үгийн эхний хагуу гийгүүлэгч:

тув: <i>дозу</i> ,	мон бич: <i>тосун</i> ,	монг: <i>дос тос</i> ,
тув: <i>дончу</i> ,	мон бич: <i>тобчи</i> ,	монг: <i>товч</i> ,
тув: <i>дептер</i>	мон бич: <i>дэбтэр</i>	монг: <i>дэвтэр тэвтэр</i>
тув: <i>кичээл</i>	мон бич: <i>кичиеэл</i>	монг: <i>хичээл гичээл</i>
тув: <i>хажсаа</i>	мон бич: <i>хасиу-а</i>	монг: <i>хашаа гашаа г.м.</i>

Д. Баасанбат

Эрдэмтэн В.И.Золхоев (Фонология и морфонология агглютинативных языков, Новосибирск, 1980) сэлгэврийг хам цагийн үүднээс судалж “яв-яф, цэцэг-цэцэк, залуучууд-залуучуут” гэх мэтээр илэрхийлбэрийн хувилбарыг харьцуулж “в-ф, г-к, д-т” зэрэг сэлгэвэр(морфема) байдгийг тодорхойлсон байна. Энэчлэн нэрлэвэр ба илэрхийлбэрийн хувилбар нь авианы болоод бүтээврийн байрлалаас шалтгаалан үүсэх ажээ. Хам цагийн үүднээс монгол тува хэлний дундын үгийн авианы сэлгэц хувьслыг гол ба гол бус аялгууны ялгаа бүхий “халх-галх, талх-далх, нохой-нокаа, хагас-хагад” гэх мэт сэлгэц байхаас гадна ялгаж хэлэлцэх “чийрэг” чаараг, торних-тарних, халцлах-холцлох, за-жа, бяцхан-бичкэн, нулимс-нилбус, одоо-эдүгээ” гэх мэт сэлгэц байна. Авианы хувьслыг монгол бичгийн хийгээд дурсгал бичигт зохих хэмжээгээр тусгасаар ирсэн байдаг тул сэлгэх ёсонд анхаарахгүй байж болохгүй юм.

Монгол хэлний хамжин шүргэх “з, ж, ц, ч” авиа нь түүхэн хөгжлийн явцад “д, т” авианаас үүссэн бөгөөд өнөөгийн монгол хэлнээ өөр хоорондоо эсрэгцэж хамжих “д, т”, шүргэх “с, ш” авиатай эсрэгцдэг нь хэлний дотоод онцлогийг тусгахын зэрэгцээ хос авиа дан болж, дан авиа хос болж хэлэгдэх зүй тогтлыг харуулж байгаа юм.

Ингээд хоёр хэлний дундын үгийн гийгүүлэгч авианы тохирлыг товчоолбол:

Монгол хэлэнд “б” авиа, тува хэлэнд “о” авиатай, монгол хэлний үгийн 1-р үеийн “б” гийгүүлэгч тува хэлнээ сугарсан тохирол байна. Жишээ нь:баадан-аадан,

Монгол хэлэнд “б” авиа, тува хэлэнд “м” авиатай, анбаар-анмаар, баатар-маадыр, бантан-мантан, мандын, бойтог-мойтук, бөх(тэмээний)-мөген, бөх(хүн)-мөге,

Монгол хэлний шуугиант, хамжих, дуут гийгүүлэгч “б” тува хэлэнд аниршсан “и” гийгүүлэгчтэй тохирч байна. Тува хэлэнд монгол хэлнээс авсан үгийн эхний “п” тийм ч их байдаггүй. Энэ утгаараа тува хэл монгол хэлтэй ойр дөт байдаг. Хаана “п” гийгүүлэгч хаана байна тэнд “б” гийгүүлэгч байна гэдэг нь зөвхөн зээлэн авсан үгэнд л тохиолдоно. Жинхэнэ биеэ даасан монгол үгэнд “б” байна. Тийм учраас монгол хэлнээс гаралтай “п” үсгээр эхэлсэн цөөхөн хэдэн үгсийн дотроос ихэнх нь сул (дуут) “б” үсгээр эхэлсэн сурвалж монгол үгстэй нийцэж, зөвхөн тоотой хэдхэн үг л монгол “п”-г бүтэцдээ хадгалж үлдсэн нь сонирхол татахгүй байхын аргагүй юм. Жишээлбэл нэг талаас:

тув: *палыыр, паалыыр, парыыл* мон бич: *баригул* “иш бариул”, монг: *бариул*

тув: *падарчы* монбич: *бадарчи*, монг: *бадарчин* “даяанчлагч лам, хэсүүлчин”,

тув: *пар*: “бар”, мон бич: бар “араатан”, “хэвлэлийн”, монг: бар “хэвлэлийн хэв”,

тув: *пааран* “штаб, казарм”, монг: *хуаран*, “цэргийн лагерь, хуаран”,

тув: *пакса* утгачилбал “адууны сүүлээр хийсэн багс, мон бич: *багса*, гм. Эхний үсгийн “б” > “и” шилжилт нь сүүлд зээлдэгч тува хэл дээр явагдсан бололтой. Жишээ нь, багс-пакса, бадарчин-падарчы, бар-пар, бариул-палыыр,

Монгол хэлэнд “өг” нь, тува хэлний “гб” авиатай тонгорч сэлгэж, авгай (хүндэтгэл)- агбай,

Монгол хэлэнд үгийн тэргүүн бус үед орсон “в” авиа, тува хэлэнд “б” авиатай, дөв дөрвөлжин-дөп дөрбэлчин, арвай-арбай, арван-арбан, сорви-сорбу, тайван-тайбын, тарвага-тарбаган,

Монгол хэлэнд үе төгсгөх “в” авиа, тува хэлэнд “вы” хэлбэртэй болсон, аврал-авырал, авхай-авыкай,

Үг бүтээвэр дэх хоёр авиа харилцан байраа солихыг авиа тонгорох гэдэг. Монгол- тува хэлэнд “в-г, г-ш” тонгорох үзэгдэл байна. өвөг-өгбэ, багш-башкы, богширго-бошкурга, догшин-дошкун, түгшүүртэй-дүшкүүрлүг, хогшил-кошкул,

Д. Баасанбат

Монгол хэлний шуугиант, хамжих, дуут гийгүүлэгч “б,в” тува хэлэнд аниршсан “н” гийгүүлэгчтэй тохирч байна. авдар хайрцаг- аптара хааржак, авдар-аптара, давхар-дапкыр, дөв дөрвөлжин-дөп дөрбэлчин, нэвтэрхий-нептергей, тавлах-таптаар, тавтай-таптыг, тив-дип, хав-кап, хаяавч-хаяагчы, хов-хоп, ховлох-хоптаар, ховч-хопчу, эв найрамдал-эп найырал, эв-эп, эвгүй-эпжок, элдэв-элдеп,

Монгол хэлэнд “в” авиа, тува хэлэнд “ш” авиатай тохирох нь, хавцал-кашпал,

Монгол хэлэнд “в” авиа, тува хэлэнд “м” авиатай сэлгэж тохирох нь, аравнайлах-арамбайлаар,

А.М.Щербак тува үгсийн сан дах монгол зээлдсэн үгст үгийн язгуурын эхэнд (н) үсгээр эхэлсэн үгсийг оруулжээ.

Мөн тува хэлний онцгой бус үгийн эхэнд бичигдэх (н),(л) тодорхой өөрчлөгддөг ба (н) сугардаг. тув: “элээн”, монг. “нэлээн”, Зарим нэг аялгуунд энэхүү (н) нь хадгалагддаг.

Монгол хэлэнд хэлний хойгуурхи “н” авиа, тува хэлэнд “н” авиатай тохирох нь, агнах-аннаар, агнуур-аннаашкын, антай-анныг, магнай-маннай, магнаг-маннык, сөгнөх-сөннээр гэх мэт монгол бичгийн хэлбэрийг хадгалсан үгс байна.

Монгол хэлэнд “н,г” авиа, тува хэлэнд “Ө” авиатай тохирох нь, баян- бай, алаг-ала, өнгө-өнг\,

Монгол хэлэнд “н” авиа, тува хэлэнд “м” авиатай тохирох нь, ертөнц-өртемчэй

Монгол хэлэнд “г” авиа, тува хэлэнд “к” авиатай тохирох нь, адаг-адак, адсага-адаска, аймаг-аймак, амраг-амырак, бараг-барык, гааль-каайлы, гагнах-каннаар, гайхамшиг-кайгамчык, галзуу-калчаа, гам (хайр)-кам хайыра, ган-кан, ганга (агь)-кангы, гарз-каража, гачигдах-качыгдаар, гапуудал-кажыдал, гичгэнэ-кичигене, гишүүн-кежигүн, гозгор-кожагар, гол-кол, горим-корум горьдох-кордаар, гудамж-кудумчу, гуйранч-куурумчу, гуна-кунан, гутрал-кударал, гэгээрэл-кегээрел, гээг-кежеге, гэм-кем, даатгах-дааткаар, дарлагч-дарлакчы, засаг-чазак, захиалагч-чагыдыкчы, зодог-содак, зориг-сорук, магтаал-мактал, омог-омак, орлогч-оралакчы, өтөг-өдек, саадаг-саадак, сархинаг-саргыяк, саяг-саяк, сонгогч-сонгукчу, сүсэг-сүзүк, таваг-тавак, тараг-тарак, төвөг-түвек, тусгай-тускай, тэвэг-тевек, тэнэг-тенек, уг-ук, удирдагч-удуртукчу, уршиг-уржук, устгах-узуткаар, утга-утка, үхэг-үгек, хайнаг-хайнак, хайрцаг-хааржак, халаг-халак, халдагч-халдакчы, хишиг-кежик, хоног-хонук, хувраг-хуурак, хувьсгал-хувискаал, худаг-кудук, хүндэтгэл-хүндүткел, хэрэг-херек, хээрэг-хээрик, шуудаг-шудак,

Монгол хэлэнд “г” авиа, тува хэлэнд “х” авиатай, Монгол хэлний угийн сул, дуутай гийгүүлэгч болох “г” нь “х” болдог. Жишээ нь: гэрэл-херел, гавьяа-хавьяа, гажих-хажыыр, гай барцад-хай бачыг, гайтай-хайлыг, говь-хову, гомдох-хомудаар, гомдол-хомудал,

Монгол хэлэнд “г” авиа, тува хэлэнд “с” авиатай, тэгш-дески,

Монгол хэлэнд “д” авиа, тува хэлэнд “з,т” авиатай, Тува ярианы хэлэнд байх “д-т”-ийн сэлгэц монгол хэлэнд байх сэлгэлттэй зарим талаар ялгаатай. Дорнын ярианы хэлэнд хүчтэй гийгүүлэгч монгол хэлний адил хадгалагдан үлдсэн ба харин сул гийгүүлэгч нь чангарсан байдаг. Монгол хэлний гарал үүслийг харьцуулан үзэхэд тэдний анхны дүр нь бусдаас ялгаатай. Монгол хэлний жишээн дээрх чанга гийгүүлэгчийн шинж нь эхний бус үеийн гийгүүлэгчийн шинжийг агуулдаггүй. Гэхдээ бүгд өөрийн шинжээ агуулж байдаг. Тува хэлний хүчтэй чанга гийгүүлэгч (т) нь монгол хэлний сул дуут (д) гийгүүлэгчтэй харгалзах нь харьцангуй цөөн тохиолддог.

Иймэрхүү зохицол илэрч байгаа нь тува хэлэнд тодорхой нөхцөлд (сул ба хэт сул гийгүүлэгчийн, мөн тэдгээрийн хослолын өмнө) эхний сул гийгүүлэгчийг чангатгах чиг хандлага байна гэсэн таамаглалд хүргэж байгаа юм. Уг чиг хандлага үүссэн хугацаа болон шалтгаан нь одоогоор

Д. Баасанбат

тодорхойгүй байна. Монгол хэлний ингэж сэлгэн хэлдэг нь тува хэлнээ уул гийгүүлэгчээс алгасан орсон чанга гийгүүлэгчийн нөлөөнөөс болсон ажээ. Энэ бол хэлний авиаг хэлэхийн талаас нь судалж буй хэрэг юм. Жишээ нь: ад буг-аза бук, алаг даага-ала таагы, бяслаг-быштак, ард-арат, ам-аас, ам тангараг-аас дангырак, сайд-сайыт, хурууд-курут, даавуу-таавы, эрдэм-эртем, эрдэмтэн-эртемден, эрдэнэ-эртнине, эд хөрөнгө-эт хөрөнги,

Тува хэлний (j) нь монгол хэлнээс зээлдсэн үгсийн эхэн дэх (j)-г хадгалагддаг байхад нийт түрэг хэлний (j) нь (č)-ээр илэрдэг. Тэгэхээр монгол хэлнээс зээлдсэн үгст орчин цагийн тува галигийн я,ё,й,ы-ээр эхэлсэн үгс орно.Зарим нэг зээлдсэн үгсэд ялангуяа хэд хэдэн тува аялгуун дээр дурдсан шинжүүд хадгалагддаггүй. Жишээ нь: Монгол хэлний зээлдсэн үгийн эхэнд бичигдэх (j)нь (n) болж хувирдаг. Энэ үзэгдэл бас уран зохиолын хэлэнд ашиглагддаг.

Монгол хэлэнд “ж” авиа, тува хэлэнд “z, жы, з, ч” авиатай, анжис-ангыс, аж төрөх-ажы төрүүр, сэжиг-сезиг, аргамж-аргамчы, дамжих-дамчыыр, доромж-дорамча, жавар-чывар, жагсаал-чыскаал, жанжин-чанчын, жаргал-чыргал, жаргах-чыргаар, жигнэх-чин(г)нээр, жин (хүйтэн)-чин(г), жинхэнэ-чингине, жишиг-чижек, жишээ-чижээ, жороо-чыраа, журам-чурум, сүлжээ-сүлчээ, уламжлах-уламчылаар, хонжоо-кончаа, хорголжин-коргулчун, хэмжээ-хемчээл,

Монгол хэлэнд “з” авиа, тува хэлэнд “ж, с, ч” авиатай, азай-ажай, арз-аржан, бузар-бужар, гарз-каража, гозгор-кожагар, гэзэг-кежеге, үзүүрлэх-үжүүрлежиир, эзлэх-эжелээр, зандан-сандан, шаазгай-сааскан, заавар-саавыр, зодоон-содаа, зодог-содак, зориг-сорук, завсар-чапсар, завхуул-чакпыыл, зад (барих)-чат, зайсан-чайзан, залаа-чалаа, залуу-чалыы, залхуу-чалгаа, зан-чан, занги-чангы, зар-чар, зараа-чараа, зарга-чаргы, зарлал-чарлал, зарь (цаа буга)-чар, засаг-чазак, захиа-чагаа, заяа-чаяан, зовох-човаар, зохиол-чогаал, зохих-чогуур, зөвлөгч-чөвүлекчи, зөнөг-чөнүк, зөрөх-чөрүүр, зүгээр-чүгээр, зүдэг(муухай)-чүдек, зүйл-чүүл, зул-чула, зулгаах-чулар, зурмал-чурумал, зүрх-чүрек, зурхай-чурагай, зүс(эн)-чүзүн, зутрах-чудараар/чүдэрээр, зэвсэг-чепсек, зэл-челе, зэмлэх-чемелээр, зэмсэг-чемзек, зэрлэг-черлик, зээ-чээн, зээл-чээли, зээр-чээрэн, зээргэнэ-чээргене, олз-олча, хэнз-хенче,

Монгол хэлэнд “л” авиа, тува хэлэнд “ли, к, ы” авиатай, бээл-бээли, ажил-ажык, лав-ылап,

Мөн тува хэлний (m) үсгээр эхэлсэн үгс нь үгийн сангийн зээлдсэн үгс байдаг(монгол, орос, түрэг). Гэхдээ тува хэлний үгийн эхэнд бичигддэг (m) үсгийг заавал түрэг бус гаралтай гэж тооцох шаардлагагүй. Яагаад гэвэл үгийн эхэн дэх (m) нь (b)-ээс үүсэлтэй бөгөөд язгуурын үгс нь зээлдсэн үгсэд балархайшдаг. Монгол хэлэнд “м” авиа, тува хэлний “б,н” авиатай, малтуур-балдыыр, халамгай-халангай,

Монгол хэлэнд “н” авиа, тува хэлэнд “б” авиатай, найз-байза,

Монгол хэлэнд “с” авиа, тува хэлэнд “ж,з” авиатай, үсэг-үжүк, амсах-амзаар, асар-азыра, балгас-балгазын, боловсон-болбаазын, босго-бозага, бээс-бээзи, дайсан-дайзын, данс-данза, дүрс-дүрзү, ёс-ёзу, зэмсэг-чемзек, мөс(хүний)-мөзү, нас-назы, нойрсох-ноюрзаар, осол-озал, сүнс-сүнезин, сүсэг-сүзүк, тус-дуза, тэрсүү-дерзии, үндсэн-үндезин, хулс-кулузун, хүнс-хүнезин, хусуур-кузумуур, хүсэл-күзел, хярс-кырза, хясаа-кызаа, шүүс-сүүзүн,

Монгол хэлэнд “т” авиа, тува хэлэнд “д” авиатай, В.Котвич “т-д” авианы сэлгэц алтайн хэлнүүдэд түгээмэл үзэгдэл бөгөөд түрэг хэлнүүдэд “к-г”, монгол хэлнүүдэд “т-д, ч-ж”, тунгус хэлнүүдэд “д-т, ж-ч, г-к” авианууд ихэвчлэн сэлгэдэг гэжээ. Ж-нь: агаар тэнгэр-агаар дээр, алтан-алдын, атаа-адаан, атан-адан, балт-балды, баримт-барымдаа, баринтаг-барындак, ботго-бодаган, бүтэмж-бүдүмче, идэвх-идепхей, итгэл-идегел, намтар-намдар, өтөг-өдек, тагш-дашка, талхи-далгыг, тангараг-дангырак, тарни-дарина, тас \шувуу\-дас, тасалгаа-дазылга,

Д. Баасанбат

татвар-дадывыр, татгалзаа-дадагалзаа, тах-дага, тахиа-дагаа, тахил-дагыл, тахир-дагыр, ташаарсан-дажаараан, таяг-даяк/даянгыыш, тив-дип, тийрэн-дийрен, товч-допчу, тогтоомол-доктаамал, тонгорог-донгурак, тоос-доозун, тотгор-доктар, тоших\бух\-дожаар, төмөр-демир, түгшүүртэй-дүшкүүрлүт, түргэн-дүрген, туршлага-дуржулга, тус-дуза, тухай-дугайы, тушаал-дужаал, түшлэг-дүжүлге, түшмэд-дүжүмет, тэгш-дески, тэмдэг-демдек, тэмцэл-демисел, тэнхэл-денгел, тэрсүү-дерзии, тэтгэх-деткиир, тэх-деге, халтар-калдар, хантааз-кандаазы, хэлтэс-килдис, хэтрэх-кедерээр, этгээд-идегет,

Монгол хэлэнд “х” авиа, тува хэлэнд “х, к, г” авиатай, хахах-харар, хонох-хонар, ах-акы, хав хар-кап кара, хавх-какпа, хавцал-кашпал, хад-кат (чимис), хадаас-кадаг, халзан-калчан, хамба-камбы, хамгаалах-камгалаар, хамхуул-канмыыл, хантааз-кандаазы, ханхайх-кангайар, хараа(нүд)-карак, хараах-каргаар, харанхуй-карангы, хархираа(хөөмий)-каргыраа, харц-карачал, хатан-кадын, хашаа-кажаа, хашир-кажар, хилэн(уур)-килен, хичээл -кичээл, хишиг-кежик, хогшил-кошкул, хондлой-кондаалай, хонжоо-кончаа, хонх-конга, хоч-кочу, хошуу-кожуун, хөдөө-көдээ, хөзөр-көзер, хөх-көк, хөшиг-көжеге, хөшөө-көжээ, худ-куда, худаг-кудук, хударга-кудурга, хүж-күжү, хужир-кужур, хуйх-куйга, хул-кула, хулс-кулузун, хун-куу, хундага-кундага, хүргэн-күдээ, хурууд-курут, хусуур-кузумуур, хүсэл-күзел, хүхэр-күгүр, хуц(эцэг мал)-кужа, хүч-күчү, хуяг-куяк, хэлтэс-килдис, хэнгэрэг-кенгирге, хэтрэх-кедерээр, хязгаар-кызыгаар, хярс-кырза, хясаа-кызаа, ахай-агай, ахар-агар, ахуй-агый, бурхан-бурган, бүрхэг-бүргэк, бүх-бүгү, дархан-дарган, майхан-майгын, мохох-могаар, мөнх-мөнге, мунхаг-мунгак, мухар-мугур, орхимж-оргумчу, орхоодой-оргаадай, салхи-салгын, сархинаг-саргыак, сахил-сагыл, сэхэх-сегиир, хархираа-каргираа, хонх-конга г.м. боловч аль ч чиг хандлага ньхэлний угийн гийгүүлэгчийн хувьд илүү идэвхтэй илэрч буй нь харагдаж байна.

Монгол хэлэнд “у” авиа, тува хэлэнд “ж, з, н, ш, ч, с” авиатай, боорцог- боорзак, үүц-үүже, хуц-кужа, дарцаг-дарзык, онцгой-онзагай, хавцал-кашпал, цааз-шаажы, цаг-шаг, цагаан сар-шагаа, цалам-шалба, цан-шан(г), цана-шана, царай-шырай, цовоо-шоваа, цол хоч-шола, цолмон-шолбан, цоор-шоор, цоохор-шокар, цөллөг-шөлүлгэ, цэвэр-шевер, цэглэх-шеглээр, цэрэг-шериг, цээжлэх-шээжилээр, алцгар-алчагар, онгоц-онгача, хоноц-хонача, цочих-чожуур, цэцэг-чечек, цэцэн-чечен, байцаах-байысаар, цамнах-самнаар, цохих-соктаар, цонх-сонга,

Монгол хэлэнд “ч” авиа, тува хэлэнд “ж, ш” авиатай, ахуйч-агыйжы, ач-ажы, бичиг-бижик, даамжирах-даамчыраар, ич(өвөл)-иж, ичээ-ижээн, учир-ужур, чавганц-шуваганчы, чадал-шыдал, чимээ-шимээн, чөлөө-шөлээ, чуулган-шуулган,

Монгол хэлэнд “и” авиа, тува хэлэнд “ж, ё, ч” авиатай, аршаан-аржаан, ашиг-ажык, бушуу-божуу, гишүүн-кежигүн, өшөө-өжээн, туршлага-дуржулга, тушаал-дужаал, түшлэг-дүжүлге, түшмэд-дүжүмет, уламжлах-уламчылаар, уршиг-уржук, бааш-баажы, хишиг-кежик, хуушуур-хуужуур, шаазгай-сааскан, шар-сарыг, заншил-чанчыл, шалтгаан-чылдагаан, шат-чада, шахах-чыгаар, шижир-чыжыр, шохой-чугай, шүтлэг-чүдүлге г.м.

Энэ бүхнээс дүгнэн үзвэл, тува хэлэнд хүчтэй ба сул гийгүүлэгч авиалбарын утгат чанар илэрдэг ба үгийн эхэн, дунд, адагт байрлаж, авиа судлалд тува хэлний энэ авиа монгол хэлэнд ихээхэн таардаг.

Хоёр хэлний дундын үгийн гийгүүлэгч авианы тохирлыг дараах байдлаар товчоолж болох юм.
б=м,п,б, в=б,г,п,ш,м,ва,вы, вг=гб, г=к,ш,х,с,б, д=з,т, ж=г,з,ч,жы, з=ж,с,ч, ча, л=к,ы,ли, м=б,н, н=м,б, п=б, с=ж,з\а,о,у, ы,е\, т=д, х=р,к,г,аар, ц=ж,з,п,ш,ч,с, ч=ж,ш, ш=ж,с,ч,б,ш,

Д. Баасанбат

Дуутай гийгүүлэгчийн уг шинжид хөөмийн түрлэгтэй эгшиг тогтмол илрэх үзэгдэл анхнаасаа сулбууу дуу султай хоёр эгшгийн хоорондох гийгүүлэгчийн байрлалд болон хоёр гийгүүлэгчийн нэгдлийн өмнө ажиглагдаж байна. Заримдаа нууц гийгүүлэгч дагалдах юм.

тув: *амдан* “хоол тэжээлийн амт”, мук: *амта*, мон бич: *амта*, монг: *амт*

тув: *аржсыл* “алчуур”, мон бич: *арчигур*, монг: *алчуур*,

тув: *чалгаа* “залхуу хойрго”, мон бич: *жалкагу*, монг: *залхуу*,

тув: *берге* “хүнд хэцүү бэрхшээлтэй”, мон бич: *бэркэ*, монг: *бэрх*,

тув: *мандын* “гурил хийж хутгасан шөл”, мон бич: *бантанг*, монг: *бантан*,

тув: *элзет* “элсүүлэх, татан оруулах”, мон бич: *элсэ-*, монг: *элс-*,

тув: *мойтук*, мон бич: *бойтуг*, монг: *бойтог*, “нялх хүүхдийн гутал”,

тув: *бактаа* “бүрэлдэхүүнд орох”, мон бич: *багта-*, монг: *багта*,

тув: *башкы* “багш сурган хүмүүжүүлэгч”, мон бич: *багси*, монг: *багш*, тув: *дакпыр* мон бич: *дабхур*, монг: *давхар*, “давхарга, хос, давхраа”,

тув: *сексиирге*, мон бич: *сэгсэгүргэ*, монг: *сэгсүүрэг*, “том биетэй хурганы арьс” гм.

Монгол хэлний тулгуур эх бичгүүдэд тува хэлний үгс дуутай, эхний биш, сул гийгүүлэгчийн байр руу орж байгаагаас дуутай ба сул гийгүүлэгч сэлгэх үзэгдэл бэлхнээ харагдаж байна. Тэдгээрийн байранд нэлээд тохиолдолд хөөмий эгшиг байхгүй байх болно. Тухайлбал: өмнө нь тохиолдох гийгүүлэгч “н”+шүргэх “з”<“с” байна.

тув: *данзы*, мон бич: *дангса*, монг: *данс* “бүртгэл ном, цэс, баримт”,

тув: *дүнзе* “дунза, тамхины төрөл”, мон бич: *дүнгсэ*, монг: *дүнс*,

тув: *чинзе*, мон бич: *жингсэ*, монг: *жинс*,

тув: *дайзын* “өшөөтөн, эсэргүү” мон бич: *дайисун*, монг: *дайсан*,

тув: *чанчыл*, мон бич: *жангсил*, монг: *заншил* гм,

Үүнээс харахад анирт эгшгийн энэ тохиолдолд тува хэлний эгшгийн эхэн үеийн өмнө байх хөөмийн эгшиг дуудагдахгүй байх ба сугарах болсон байна .

Тува хэлний үгийн эхний дуутай гийгүүлэгчийн уг эх нь анирт гийгүүлэгчтэй байна. Жишээ нь:

тув: *дагыр*, мон бич: *такир*, монг: *тахир*, “далий, махийлгасан”,

тув: *дойду* “тоть”, мон бич: *тоти*, монг: *тоть*,

тув: *дүлгүүр* “түлхүүр”, мон бич: *түлкигүр*, монг: *түлхүүр*, калм *түлкүр*,

тув: *казы*, мон бич: *касу*, монг: *хас-* “тайрах, багасгах, үгүй болгох”,

тув: *канмыыл*, *каъмгыыл* “хамхуул”, монг: *хамхуул*,

тув: *кежик*, мон бич: *кэсиг*, монг: *хишиг* “өглөг, өргөл”,

тув: *чалчы* “агсамнах, хэрэлдэх”, монг: *чалч*, “дэмий донгосох”,

тув: *чаржа* “мах царцах, цас мөхөөлдөх”, мон бич: *чарча-*, монг: *царц*,

тув: *чүдүлге*, мон бич: *ситүлгэ*, монг: *шүтлэг*, “үнэмшил, хүсэл”,

тув: *чыгам*, мон бич: *сикам*, монг: *шахам*,

Цөөн хэдэн тохиолдолд хөөмийн эгшиггүй байдаг. Тэр нь дуутай гийгүүлэгчийн өмнө байдаггүй.

тув: *көгээр* “том ширэн дашмаг”, мон бич: *көжүүр*, монг: *хөхүүр*,

тув: *сүге* “сүх”, мон бич: *сүхэ*, монг: *сүх*,

тув: *үгүл* “нас барах”, мон бич: *үкүл*, мук *үкүл*, монг: *үхэл*,

тув: *чйчаан*, монг: *чййчаан* гэх мэт.

Зарим тохиолдолд шал өөр тэмдэглэсэн зүйл ч байна. Орчин цагийн тува хэлэнд:

тув: *кавы*, мон бич: *каби*, монг: *хавь* “ойр оршин байх юмс” г.м.

Д. Баасанбат

Урианхай хэлний энэ сэлгээнээс гадна сул гийгүүлэгчийн өмнө энэ гийгүүлэгчийн үзэгдэл илүү их байна.

тув: “гаагы”-ширэлдсэн бөөн үс ноос, мон бич “дагаки”, монг”даахь”

тув: “терезин” мон бич “дэрэсүн”, монг “дэрс”,

тув: “түн”- нийлбэр дүн, мон бич-“дүнг”, монг “дүн”

тув: “тун”- том хясаа, мон бич “дунг”, монг “дун”

тув: “түр”-төрх царай, мон бич “дүри”, монг “дүр”г.м. Иймэрхүү жишээ олон биш бөгөөд зүүн зүгийн аялгад илүү тархсан байдаг.

Монгол хэлний “б, м, г, ж, з, л, с, х, ц, ш” гийгүүлэгч авиа тува хэлний олон гийгүүлэгчтэй сэлгэсэн нь бусад гийгүүлэгчээс их байна.

Ном зүй

1. Баасанбат.Д. Монгол-манж бичгийн хэлний дундын үг. Уб., 2008.
2. Базаррагчаа.М. Монгол хэлний авиа сэлгэх ёс. Уб.,1987.
3. Болд.Л. Уйгар урианхай хэлэнд орсон монгол үг. Өв.Мо.1985.
4. Гагаа.Ч. Тува өвгөний дурдатгал, Уб., 2009. 10-р тал.
5. Даваасүрэн.Б. Алтай овгийн хэлнүүд.Уб., 2005. 1-р тал.
6. Дорлиг.Ц нар Тува монгол толь. Өлгий., 1994.
7. Зоригту.Го. Монгол төрлийн хэл ба түрэг төрлийн хэлний үгсийн харьцуулсан судлал. Өв.Мо., 2000. 9-р тал.
8. Исхаков.Ф.Г нар. Грамматика тувинского языка. Фонетика и морфология. М.,1961.
9. Ропре.Н. Introduction to Altaic Linguistics. Weisbaden.,1965.
10. Потанин. Г.Н. Очерки Северо-Западной Монголии, вып. IV, Спб., 1883, с.379.
11. Пунцаг.Т. Монгол Тува-Орос толь, Уб,1985.
12. Руссо-тувинский словарь (под ред. Д.А.Монгуша.) М., 1980.
13. Рашид Ад дин Судрын чуулган.1952.123-р тал.
14. Сат.Ш.Ч нар. Амгы тыва литературлуг дыл. Лексикология, фонетика, морфология. Кызыл.,1980.
15. Татаринцев.Б.И. Монгольское языковое влияние на тувинскую лексику. Кызыл., 1976.
16. Төмөртоого.Д. Монгол хэлшинжлэлийн онол, түүхийн асуудлууд. Уб., 2002. 1-р тал.
17. Тыва-Орус словарь, Русско-Тувинский словарь. (под редакцией Д.А.Монгуша) Москва 1980,
18. Ууганбаяр.М. Тува хэлэн дэх монгол зээллэг үгсийн авиан зүйн онцлог. Уб., 2008. МУИС.МХСС.ЭШБ №-XXIX(300) .138-142-р тал.

Abstract

This article, “The harmony of common lexical consonants of Mongolian and Tuvan”, discusses the harmony of phonetic forms and semantics of consonants are shown through practical examples.

Consonants from both languages are analyzed based on distinct features of consonant-to-consonant correlation, and consonant replacement with another consonant.

Here in, the Mongolian consonant phonemes “б, в, г, ж, з, л, с, х, ц, ш” are compared with relatively large amount of consonant phonemes of Tuva language.